



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот  
2023 он

УДИРТГАЛ

<b>НЭГ.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>5</b>
1.1.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ ТУХАЙН ЖИЛИЙНХЭЭ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	9
<i>Хавсралт 1.</i> “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний зорилтот түвшинд хүрсэн 68 төсөл, арга хэмжээ	24-28
<i>Хавсралт 2.</i> “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт нь бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	29-40
1.2.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ЗААСАН ЗОРИЛТЫН ХЭДЭН ХУВЬД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	14
<i>Хавсралт 3.</i> Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	41-50
<i>Хавсралт 4.</i> Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний биелэлт	51-58
1.3.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ЗААСАН ЗОРИЛТЫН ХЭДЭН ХУВЬД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	17
<i>Хавсралт 5.</i> “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт нь Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрт тусгасан зорилтот түвшинд хүрээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	59-74
<i>Хавсралт 6.</i> “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг үнэлсэн байдал	75-86
<i>Хавсралт 7.</i> “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй болон үр дүн тодорхойгүй үзүүлэлт	87-89
<b>ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗААСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ БҮРЭН ХЭРЭГЖСЭН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ</b>	<b>20</b>
<i>Хавсралт 8.</i> “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд заасан төсөл, арга хэмжээний бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт, шалтгаан нөхцөл, дүн шинжилгээний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх санал	90
<b>ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>21</b>
<b>Хүснэгтийн товьёг</b>	
Хүснэгт 1. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээ, бодлого тус бүрээр	
Хүснэгт 2. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн уялдаа	

Хүснэгт 3.Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан арга хэмжээ нийцсэн байдал

Хүснэгт 4.Бодлогын зорилт тус бүрийн санхүүжилтийн гүйцэтгэл

Хүснэгт 5.“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа

Хүснэгт 6.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүлэг, зорилт, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, шалгуур үзүүлэлтийн тоо

Хүснэгт 7.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн үнэлгээ

Хүснэгт 8.Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтийн явцын хэрэгжилтийн үнэлгээ, бүлэг бүрээр

Хүснэгт 9.“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдал, бүлэг бүрээр /сая.төгрөг/

Хүснэгт 10.“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтийн үнэлгээ

Хүснэгт 11.Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн уялдаа

Хүснэгт 12.Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

### **Зургийн товьёг**

Зураг 1.“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт

Зураг 2.“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээ, бодлого тус бүрээр

Зураг 3.“Төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй шалтгаан нөхцөл, нийт төсөл, арга хэмжээгээр”

Зураг 4.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн2022 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээний харьцуулалт

Зураг 5. Бүрэн хэрэгжээгүй төсө, арга хэмжээний шалтгаан нөхцөлийн бүтэц

## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор АЛСЫН ХАРАА-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван аюулгүй нийгэм, бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт, 965 арга хэмжээг 3 үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталсан болно.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нийт 6 бодлогын хүрээнд 234 зорилт, 1031 арга хэмжээг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг 6 бүлэг, 23 зорилго бүхий 300 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

### **ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ:**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн ХЭГ/312 дугаартай албан бичгээр “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ тайланг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны биелэлтийн тайлан болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.8 дахь хэсэгт “Тамгын газар энэ хуулийн 114.1, 114.5-д заасан тайланд шинжилгээ хийж, 03 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд тараана.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх бодлогын баримт бичгүүдийн 2022 оны биелэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн болно.

### **ЗОРИЛГО:**

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь тухайн жилийнхээ зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарах асуудлаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлэхэд чиглэгдэнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн

**ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ  
АРГА ЗҮЙ:**

үндсэн чиглэлд заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;

- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;
- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн эсэх болон хэрэгжээгүй арга хэмжээний талаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг болно.

Хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгож, 2022 оны дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу уг журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу үнэлсэн болно.


## НЭГ.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-г 6 бүлэг, 23 зорилт бүхий 300 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд Улсын Их Хурлын Тамгын газраас тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үр дүнгийн **дундаж үнэлгээ 65.2 хувьтай байгаа нь** Засгийн газраас хэрэгжилтийг 67.5 хувь гэж үнэлж ирүүлснээс 2.3 нэгж хувиар буурсан.


Үнэлгээ буурахад “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 300 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв хийгдэж дуусаагүй, газрын асуудал шийдэгдээгүй, санхүүжилт батлагдаагүй, зорилт арга хэмжээний хэрэгжилтийн хувь шалгуур үзүүлэлтийг хангаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүнд гарч эхлээгүй, авсан арга хэмжээ, үр дүнг тайлагнаагүй, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэгтэй холбоотой 32 арга хэмжээг аргачлалын<sup>1</sup> дагуу бууруулж үнэлсэн нь нөлөөлсөн.

**Зураг 1.** “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 300 арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээр үр дүнтэй хэрэгжсэн 68 арга хэмжээ буюу 22.7 хувь, тодорхой үр дүнд хүрсэн 119 төсөл, арга хэмжээ буюу 39.7 хувь, эрчимжүүлэх шаардлагатай 87 төсөл, арга хэмжээ буюу 29.0 хувь, үр дүнгүй буюу зорилтот үр дүнг хангаагүй 26 төсөл, арга хэмжээ буюу 8.7 хувь байна.



“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний нийт гүйцэтгэл, үр дүнгийн **дундаж үнэлгээ 65.2 хувьтай** байгаагаас “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого хамгийн өндөр буюу 85.6 хувийн биелэлттэй бол Ногоон хөгжлийн бодлого хамгийн бага буюу 57.1 хувийн биелэлттэй, Хүний хөгжлийн бодлого 65.4 хувь, Эдийн засгийн бодлого 60.6 хувь, Засаглалын бодлого 67.5 хувь, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого 81.3 хувийн дундаж үнэлгээтэй байна.



**Зураг 2.** “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээ, бодлого тус бүрээр

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлал


**Хүснэгт 1.**“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээ, бодлого тус бүрээр

№	Бодлого	Хэрэгжилтийн дундаж хувь	
		Засгийн газрын үнэлгээ	УИХ-ын Тамгын газрын үнэлгээ
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	89.3%	85.6%
2	Хүний хөгжлийн бодлого	66.5%	65.4%
3	Эдийн засгийн бодлого	61.2%	60.6%
4	Засаглалын бодлого	70.2%	67.5%
5	Ногоон хөгжлийн бодлого	69.0%	57.1%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	84.6%	81.3%
<b>Дундаж үнэлгээ</b>		<b>67.5%</b>	<b>65.2%</b>
		<b>2.3 нэгж хувиар буурсан</b>	

*Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”*

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтээс харахад зорилтот түвшинд хүрсэн 68 арга хэмжээ, зорилтот түвшинд хүрээгүй буюу бүрэн хэрэгжээгүй 232 арга хэмжээ байна.

**Зураг 3.** Төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй шалтгаан нөхцөл, нийт төсөл, арга хэмжээгээр



Арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг холбогдох шийдвэр удаан гарсан, төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй байсан, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй, дотоодоос хамааралгүй хүчин зүйлсээс шалтгаалсан зэрэг төрлүүдэд ангилж, давхардсан тоогоор нь аваад үзвэл дараах зурагт харуулсан тоон үр дүн гарч байна. /Төсөл, арга хэмжээ бүрийн шалтгаан, нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хавсаргав./

Дээрх зургаас Засгийн газар цаашид төсөл, арга хэмжээг үр дүнтэй төлөвлөх, холбогдох үйл ажиллагааг шуурхай, оновчтой зохион байгуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

**“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-г дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлсэн байдал:**

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хэрэгжүүлэхээр заасан нийт 1031 арга хэмжээнээс (давхардсан арга хэмжээний тоогоор) 328 арга хэмжээ, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-г хэрэгжүүлэхээр заасан нийт 252 арга хэмжээнээс (давхардаагүй арга хэмжээний тоогоор) 75 арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагджээ.

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 300 арга хэмжээнээс 276 арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан 328 арга хэмжээтэй уялдаж байгаа бөгөөд бодлогын баримт бичгүүдийн уялдаа 92.0 хувьтай байна. Харин Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт арга хэмжээнээс 24 арга хэмжээ буюу 8.0 хувь нь "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан арга хэмжээтэй уялдаагүй байна.

**Хүснэгт 2.** Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө болон "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн уялдаа

д/д	Бодлого	УХЖТ-нд тусгасан нийт арга хэмжээ	Агуулгын хувьд уялдаж буй арга хэмжээний тоо		Бодлогын баримт бичгүүдийн уялдаа /хувиар/
			УХЖТ-нд тусгасан арга хэмжээ	ЗГҮАХ-т тусгасан арга хэмжээ /давхардсан тоогоор/	
1	"КОВИД-19" халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	8	8	8	100%
2	Хүний хөгжлийн бодлого	80	79	79	99%
3	Эдийн засгийн бодлого	115	107	156	93%
4	Засаглалын бодлого	53	53	53	100%
5	Ногоон хөгжлийн бодлого	20	20	22	100%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	24	9	10	37.5%
<b>Нийт</b>		<b>300</b>	<b>276</b>	<b>328</b>	<b>92.0%</b>

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан"

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 300 арга хэмжээнээс "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан 328 арга хэмжээтэй уялдаж буй 276 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл:

- "үр дүнтэй" буюу 100 хувийн 57 арга хэмжээ;
- "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 83 арга хэмжээ;
- "эрчимжүүлэх шаардлагатай" буюу 31-69 хувийн хэрэгжилттэй 32 арга хэмжээ;
- "үр дүнгүй" буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 100 арга хэмжээ;
- "үнэлэх боломжгүй" буюу нууцын журмаар тайлагнасан 4 арга хэмжээ тус тус байна.

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 243 арга хэмжээнээс 75 арга хэмжээ буюу 30.8 хувь (давхардаагүй арга хэмжээний тоо) нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан байна.



**Хүснэгт 3.** Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд  
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан арга  
хэмжээний нийцсэн байдал

д/д	Бодлого	ТЖҮЧ-ийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	Хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнд эзлэх хувь
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	1	6.2%
2	Хүний хөгжил	49	10	20.4%
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	27	4	14.8%
4	Эдийн засаг	35	10	25.8%
5	Засаглал	25	7	28.0%
6	Ногоон хөгжил	18	16	88.9%
7	Амар тайван, аюулгүй байдал	23	7	30.4%
8	Бүс, орон нутгийн хөгжил	29	14	48.3%
9	Улаанбаатар ба дагуул хот	21	6	28.6%

*Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан"*

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд заасан арга хэмжээний хэрэгжилт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан арга хэмжээний хэрэгжилтийн хэдэн хувьд хүрсэн эсэх болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д заасан арга хэмжээний хэрэгжилтийн хэдэн хувьд хүрсэн эсэхийг Засгийн газраас ирүүлсэн бодлогын баримт бичгүүдийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн мэдээлэлд үндэслэн тодорхойлох боломжгүй байна.

Учир нь Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан арга хэмжээний хэрэгжилтийг багцалж дүгнэсэн, 2021, 2022 онд хэрэгжсэн арга хэмжээнүүдийн биелэлтийг “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд заасан арга хэмжээний биелэлттэй уялдуулж тодорхойлоход арга хэмжээнд тусгагдсан үзүүлэлтүүдийн тооны зөрүү, арга хэмжээг хэрэгжүүлэх цаг хугацаа, төсөл хэрэгжүүлэх байршил, төсөлд хамаарах хувьсагчдын шинж чанар, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч, төслийн үр шимийг хүртэгсэд буюу хэрэглэгчид, төслийн санхүүжилт, хүний нөөц, зохион байгуулалт зэрэг хүчин зүйлүүд ялгаатай болон тодорхой бус байсан.

**Санхүүжилтийн гүйцэтгэл:**

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээний 31.5 хувийг санхүүжүүлсэн гэсэн гүйцэтгэлтэй байна. Санхүүжилтийн гүйцэтгэлийг бодлогуудын хувьд эрэмбэлж авч үзвэл “КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын санхүүжилт хамгийн өндөр буюу 115.2 хувийн хэрэгжилттэй, Засаглалын бодлогын санхүүжилт хамгийн бага буюу 3.9 хувийн хэрэгжилттэй гарсан байна.

**Хүснэгт 4.** Бодлогын зорилт тус бүрийн санхүүжилтийн гүйцэтгэл

№	Бодлого	Төсөвлөсөн /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
1	“КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	300,320.0	346,077.9	115.2%
2	Хүний хөгжлийн бодлого	851,227.3	381,666.1	44.8%
3	Эдийн засгийн бодлого	8,145,123.8	2,157,269.9	27.0%
4	Засаглалын бодлого	266,489.0	10,443.9	3.9%
5	Ногоон хөгжлийн бодлого	304,943.7	80,402.1	26.4%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	1,843,897.3	715,932.2	38.8%
<b>Ерөнхий үр дүн</b>		<b>11,712,001.1</b>	<b>3,691,792.1</b>	<b>31.5%</b>

## **Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилт хангагдаагүй шалтгаан:**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-т “Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшнийг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно.” гэж, 6.2.2.5-д “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг “0” хувь.” гэж тус тус үнэлэхээр журамласан.

Тус аргачлалын дагуу төлөвлөгөөнд заасан арга хэмжээнүүдээс “0” хувьтай үнэлэгдсэн буюу хэрэгжилт нь хангагдаагүй нийт 26 арга хэмжээ байна. Энэ нь нийт арга хэмжээний 8.7 хувийг эзэлсэн үзүүлэлт болж байна. Тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй нь зураг төсөв болон санхүүжилт нь батлагдаагүй, төндөр амжилтгүй болсон, төсөл, арга хэмжээ судалгааны шатанд байгаа, гэрээ гүйцэд хийгээгүй зэрэг төсөл, арга хэмжээний бэлтгэлийг бүрэн хангаагүйтэй холбоотой шалтгаануудаас хамаарсан байна.

### **1.1.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ ТУХАЙН ЖИЛИЙНХЭЭ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2.3 хувиар буурахад төлөвлөгөөнд тусгагдсан 32 арга хэмжээг бууруулж үнэлсэн нь нөлөөлсөн.

Төлөвлөгөөнд тусгагдсан 32 арга хэмжээний үнэлгээний бууралт нь зураг төсөв хийгдэж дуусаагүй, газрын асуудал шийдэгдээгүй, санхүүжилт батлагдаагүй, зорилт арга хэмжээний хэрэгжилтийн хувь шалгуур үзүүлэлтийг хангаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй, авсан арга хэмжээ, үр дүнг тайлагнаагүй, арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэг шалтгаануудтай холбоотой байна.

Дундаж үнэлгээгээрээ “КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого, арга хэмжээ” хамгийн өндөр буюу 85.6 хувийн биелэлттэй, “Ногоон хөгжлийн бодлого” хамгийн бага буюу 57.1 хувийн хэрэгжилттэй байна.

Дунд хугацааны бодлогын бичиг баримтуудад тусгагдсан Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд хамгийн өндөр буюу 91.7 хувьтай туссан хэдий боловч гүйцэтгэл нь хамгийн бага буюу 57.1 хувьтай байна.

Жилийн төлөвлөгөөний нэлээд олон арга хэмжээний хүрэх үр дүнг ерөнхийлөн заасан, тухайлбал хүрэх үр дүнг “үе шаттай гүйцэтгэсэн байх”, “үргэлжлүүлэн хэрэгжүүлэх” гэх зэргээр тодорхойлсон нь арга хэмжээний биелэлтийг хэмжих, дүгнэх боломжийг хязгаарлаж байна.

Хэрэгжүүлэх шатандаа зорилтот түвшинд заасан арга хэмжээний байршил, хамрах хүрээг өөрчилж тайлагнасан, жилийн төлөвлөгөөнд эх үүсвэргүй арга хэмжээнүүд он дамжин хэрэгждэг, төлөвлөлтийн үндэслэл тооцоо дутуу, түүнчлэн УИХ-аас баталсан шийдвэрт заасан тоо, хэмжээ, байршилд өөрчлөлт оруулж, шаардлагатай хөрөнгийг Засгийн газрын түвшинд зохицуулалт хийж шийдвэрлэсэн тохиолдлууд гарч байна. Түүнчлэн санхүүжилт нь хийгдээгүй байхад гүйцэтгэл нь өндөр хувьтай хэрэгжсэн арга хэмжээ тайланд тусгагдсан байсан.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийг бүлэг тус бүрийн хувьд үнэлгээ хийсэн дүнг авч үзвэл:

**“Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах** бодлогын хүрээнд нийт 8 арга хэмжээг Засгийн газраас 89.3 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлснийг 85.6 хувийн гүйцэтгэлтэй гэж 3.7 хувиар бууруулж үнэллээ.

Эдгээрээс үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 5 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ тус тус байна.

**Хүний хөгжлийн бодлогын хүрээнд** 6 зорилт 80 арга хэмжээг Засгийн газраас 66.5 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлснийг 65.4 хувийн гүйцэтгэлтэй гэж 1.1 хувиар бууруулж үнэллээ. Эдгээрээс үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 23 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 30 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн хэрэгжилттэй 16 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ тус тус байна.

**Эдийн засгийн бодлогын хүрээнд** 7 зорилт 115 арга хэмжээг Засгийн газраас 61.2 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлснийг 60.6 хувийн гүйцэтгэлтэй гэж 0.6 хувиар бууруулж үнэллээ. Эдгээрээс үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 20 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 46 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн хэрэгжилттэй 41 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ тус тус байна.

**Засаглалын бодлогын хүрээнд** 6 зорилт 53 арга хэмжээг Засгийн газраас 70.19 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлснийг 67.5 хувийн гүйцэтгэлтэй гэж 2.7 хувиар бууруулж үнэллээ. Эдгээрээс үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 биелэлттэй 6 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 21 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хувийн хэрэгжилттэй 17 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 1, хэрэгжилтийг үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ тус тус байна.

**Ногоон хөгжил бодлогын хүрээнд** нийт 20 арга хэмжээг Засгийн газраас 69.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлснийг 57.1 хувийн гүйцэтгэлтэй гэж 11.9 хувиар бууруулж үнэллээ.

Эдгээрээс үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ тус тус байна.

**Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд** 2 зорилт, 24 арга хэмжээг Засгийн газраас 84.6 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлснийг 81.3 хувийн гүйцэтгэлтэй гэж 3.3 хувиар бууруулж үнэллээ

Эдгээрээс үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 8 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ тус тус байна.

**Бууруулж үнэлсэн арга хэмжээний жагсаалтыг дурдвал дараах байдалтай байна.**

1. 1.1.3-т тусгагдсан “Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулах” арга хэмжээний биелэлтийг Засгийн газраас 30 хувиар үнэлснийг санхүүжилт байхгүйн улмаас 2022 онд хэрэгжээгүй, 2023 онд хэрэгжүүлэхээр санхүүжилтийг шийдвэрлэсэн хэдий ч зорилтот түвшинд заасан хүрээг бүрэн хамруулаагүй тул “0” хувийн хэрэгжилттэй;

2. 2.1.6-д тусгагдсан “Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх” төсөл арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 30 хувиар үнэлснийг барилгын зураг төсөв хийгдэж дуусаагүй, газрын асуудал шийдэгдээгүй, санхүүжилт батлагдаагүй байгаа учир уг арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай бөгөөд 0 хувийн хэрэгжилттэй;
3. 2.5.1-д тусгагдсан “Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” арга хэмжээг Засгийн газраас 50 хувийн хэрэгжилттэй гэж үнэлснийг Нийгмийн даатгалын багц хуулийг батлуулсан байна гэсэн хүрэх үр дүнд хүрээгүй буюу УИХ-аар тус багц хуулийг хэлэлцэж эхлээгүй байгаа шалтгаанаар 30 хувийн хэрэгжилттэй;
4. 2.5.8-д тусгагдсан “Орлого багатай өрхийн гишүүдийг мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх” арга хэмжээг 70 хувиар үнэлснийг сургалтад хамрагдагсдын хэдэн хувийг ажилд зуучилсан талаар дурдаагүй бөгөөд сургалтад хамрагдалт зорилтот түвшний 50 хувьтай тэнцэж байгаа зэргээс ур арга хэмжээг 50 хувийн хэрэгжилттэй;
5. 2.5.14-д “Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах” 50 хувиар үнэлснийг өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааг нийт өрхийн 30 хувийг хамруулан зохион байгуулна гэсэн зорилтот түвшиндээ хүрээгүй буюу судалгаанд 400 өрх хамруулсан байгаа тул уг арга хэмжээг 30 хувийн хэрэгжилттэй гэж тус тус бууруулж үнэллээ.
6. 3.1.2-т тусгагдсан “Зах зээл дэх хэт төвлөрлийг сааруулах, монопол, давамгайл байдлаа урвуугаар ашиглахын эсрэг бодлогын арга хэмжээг авах” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 90 хувиар үнэлснийг төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчдийн дунд өрсөлдөөнийг бий болгоогүй буюу гол үр дүн гарч эхлээгүй, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдаагүй, зарим ажлын судалгаа хийгдсэн байдалтай байгаа тул тус арга хэмжээг 70 хувийн хэрэгжилттэй;
7. 3.1.4-т тусгагдсан “Алтанбулаг” чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 30 хувиар үнэлснийг Гаалийн ерөнхий газраас бэлтгэл ажил дуусаагүй байгаа буюу гаалийн бүртгэлийн системд цогц шийдлийг олж нэвтрүүлэх, бүсийн зорчигч, тээврийн нэвтрэлтийг хурдасгахад шаардлагатай арга хэмжээ 2022 оны 12 дугаар сарын 30-нд төлөвлөгдөөгүй байх тул тус арга хэмжээг 0 хувийн хэрэгжилттэй;
8. 3.3.16-д тусгагдсан “Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 70 хувиар үнэлснийг үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажил эхлээгүй байх тул тус арга хэмжээг 50 хувийн хэрэгжилттэй;
9. 3.5.6-д тусгагдсан “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг /салхины цахилгаан станцын 2 төсөл 15 МВт, нарны цахилгаан станцын 4 төсөл 35 МВт/ хэрэгжүүлэх” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг 10 МВт-ын эх үүсвэр ашиглалтад орсон байх шалгуур үзүүлэлт бүрэн хангагдаагүй байх тул тус арга хэмжээг 90 хувийн хэрэгжилттэй;
10. 3.5.15-д тусгагдсан “Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг найдвартай эрчим хүчээр хангах” ажлын хүрээнд эрчим хүчинд холбогдоогүй үлдсэн 8, 338 өрхийг эрчим хүчинд үе шаттайгаар холбох төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг санхүүжилт бүрэн шийдвэрлэгдсэн хэдий боловч дэвшүүлсэн зорилтдоо бүрэн хүрээгүй, үйл ажиллагаанд шаардлагатай зарим барилгын ажлыг эхлүүлсэн байдалтай байгаа тул тус арга хэмжээг 90 хувийн хэрэгжилттэй гэж тус тус бууруулж үнэллээ.
11. 4.1.1. Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах арга

хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг үйлчилгээ авсан иргэдийн хүрсэн түвшин тодорхойгүйн улмаас 77.5 хувийн хэрэгжилттэй;

12. 4.1.2. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформыг хөгжүүлж нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй буюу нэн шаардлагатай төрийн үйлчилгээний 5 системийг мэдэгдэл хүргэх нэгдсэн системд холбоогүйн улмаас 90 хувийн хэрэгжилттэй;
13. 4.1.4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 30 хувиар үнэлснийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга нар оролцон ажлын төлөвлөгөөнд санал хүргүүлэн ажиллаж байгаа буюу бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа гэж үзэн 0 хувийн хэрэгжилттэй;
14. 4.1.6. Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулж, түгээх нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 70 хувиар үнэлснийг хүрсэн түвшин тодорхойгүйн улмаас 50 хувийн хэрэгжилттэй;
15. 4.1.7. “Цахим архив албан хэрэг хөтлөлт” арга хэмжээний төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах, архивын нэгжийн цахимжуулалтыг эрчимжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг боловсруулсан төсөл, цахимжуулсан архивын нэгжийн хэрэгжилтэд үндэслэн 90 хувийн хэрэгжилттэй;
16. 4.1.9. Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгох арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 50 хувиар үнэлснийг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайд нарын 2022 оны А/260, А/391, А/146, А/260 дугаар хамтарсан тушаалаар “Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байгааг харгалзаж зөвхөн бэлтгэл ажил дууссан гэж үзэн 30 хувийн хэрэгжилттэй;
17. 4.1.10. Нэгдүгээр ээлжийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын нэгдсэн төвийн үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 50 хувиар үнэлснийг зөвхөн Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв /Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан нэршил/ байгуулах Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, холбогдох судалгааг хийж, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулсан, “Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг байгуулах” сэдэвт сургалтыг зохион байгуулсан гэж үзэн 30 хувийн хэрэгжилттэй;
18. 4.1.13. Хүн ам олноор суурьшсан, аялал жуулчлалын бүс нутгуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 80 хувиар үнэлснийг зорилтот 23 баг шилэн кабельд холбогдсон эсэх нь тодорхойгүйн улмаас Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолын хавсралтад заасан журмын 6.2.2.2-д заасны дагуу 70 хувийн хэрэгжилттэй гэж тус тус бууруулж үнэллээ.
19. 5.1.1-д заасан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байх арга хэмжээний биелэлтийг Засгийн газраас 70 хувиар үнэлснийг уг арга хэмжээний тендер шалгаруулалт дуусаагүй бэлтгэл ажил хийгдэж байгаа, тодорхой үр дүн гарч эхлээгүй байгааг харгалзан 30 хувийн хэрэгжилттэй;
20. 5.1.2-т заасан “Аюултай хог хаягдлын байгууламжийг концессоор барих төсөл сонгон шалгаруулалтыг зарласан байх” арга хэмжээний биелэлтийг Засгийн газраас 70 хувиар үнэлснийг төслийн баримт бичиг болон гэрээний төсөл боловсруулах зэрэг сонгон шалгаруулалттай холбоотой үндсэн ажил хийгдэж эхлээгүй, энэ талаар тайлагнаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй байгааг харгалзан 50 хувийн хэрэгжилттэй;

21. 5.1.3-т заасан “Хэрлэн голоос ус татаж, Хэрлэн-Тооно хөндлүүрт хуримтлуулах байгууламж, Онгийн голын Цагаан бургастай хөндлүүрт урсац тохируулах зориулалттай боомтын байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байх” арга хэмжээний биелэлтийг Засгийн газраас 50 хувиар үнэлснийг санхүүжилт шийдвэрлэгдээгүйгээс байгууламж барих ажил эхлээгүй, зураг төсөл зохиох, байгаль орны үнэлгээний ажил хийгдээгүй тул бэлтгэл, боловсруулалтын шатны ажил бүрэн дууссан гэж үнэлэх боломжгүй байгааг харгалзан 30 хувийн хэрэгжилттэй;
22. 5.1.4-т заасан “Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын системийг сайжруулах, усан халаалтын зуухны түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар халах, инженерийн дэд бүтцийн бичил төвүүдийг байгуулах, Евро 5 ангиллын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх, цахилгаан хөдөлгүүртэй автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэл хийх зэрэг агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээний биелэлтийг Засгийн газар 50 хувиар үнэлснийг уг арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнаагүй, Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламжийг 50 мкг/м3 хүргэх зорилт гүйцэтгэлээр 97мкг/м3, PM10 тоосонцрын агууламжийг 107 мкг/м3-д хүргэх зорилт гүйцэтгэлээр 119мкг/м3 гарч шалгуур үзүүлэлтээ хангаагүй буурсан байгааг харгалзан 30 хувийн хэрэгжилттэй;
23. 5.1.5-д заасан “Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх” арга хэмжээг Засгийн газраас 70 хувиар үнэлснийг агаарын чанарыг хянах хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн ч 6 аймагт агаарын чанарыг 2 үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлсэн, зорилтот түвшинд заасан аймгуудыг бүрэн хамруулаагүй, 10000 дээш хүн амтай төв суурин газар агаарын чанарыг хянах ажил тендерийн маргаантай холбоотой зогссон байгааг харгалзан хэрэгжилт 50 хувьтай;
24. 5.1.11-т заасан “Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах арга хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээг Засгийн газар 70 хувиар үнэлснийг хүрэх түвшинд заасан халиун буга, хар сүүлт гэсэн 2 зүйл амьтны нөөцийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, сэлгэн нутагшуулах талаар авсан арга хэмжээ, үр дүнг тайлагнаагүй байгааг харгалзан 50 хувийн хэрэгжилттэй;
25. 5.1.14-т заасан Туул голын хамгаалалтын бүсэд орших түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, аж ахуйн нэгжээр нөхөн сэргээлт хийлгэх” арга хэмжээний биелэлтийг Засгийн газар 50 хувиар үнэлснийг нөхөн сэргээлтийг 30-аас доошгүй хувьд хийлгэсэн байх арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй гүйцэтгэл 10 гаран хувьтай байгааг харгалзан 30 хувийн хэрэгжилттэй;
26. 5.1.16-д заасан “Байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг дэмжих ногоон зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж, 1000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг уг зээлд хамруулах” арга хэмжээг Засгийн газар 100 хувиар үнэлснийг ногоон зээлийг олгох иргэн, аж ахуйн нэгжийн хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй буюу гүйцэтгэл 50 гаран хувийн биелэлттэй байгааг харгалзан 70 хувийн хэрэгжилттэй;
27. 5.1.17-д заасан “Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах” арга хэмжээг Засгийн газар 90 хувиар үнэлснийг нуурт живсэн машин, техникийг татаж гаргах ажлыг бүрэн хэрэгжүүлж, бохирдлын эрсдэлийг бууруулсан байх арга зорилтот түвшиндээ хүрээгүй, бэлтгэл шатны ажил хийгдэж байгааг харгалзан 30 хувийн хэрэгжилттэй;
28. 5.1.19-д заасан “Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгааг хийж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх” арга хэмжээг Засгийн газар 70 хувьтай үнэлснийг цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 51.5-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 23 хувьд хүргэсэн байх зорилтот түвшиндээ хүрээгүй, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан УИХ-д өргөн

мэдүүлэх бэлтгэл ажил хийгдэж байгааг харгалзан 50 хувийн хэрэгжилттэй гэж тус тус үнэллээ.

29. 6.1.1-д заасан “Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх, төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байх арга хэмжээний биелэлтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг инженерийн дэд бүтэц байгуулахад чиглэсэн бодитой бүтээн байгуулалтын ажил эхлээгүй, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, худалдан авах ажиллагаа зэрэг бэлтгэл болон боловсруулалтын шатны зарим ажил дууссан, эсхүл хэрэгжих шатандаа байгааг харгалзан 90 хувийн хэрэгжилттэй;
30. 6.1.6-д заасан “Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх” арга хэмжээг Засгийн газраас 100 хувийн биелэлттэй гэж үнэлснийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байх зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, түүнчлэн 30000 айлын орон сууцыг барих ажлыг ТХХТ-ээр хэрэгжүүлэх шийдвэр гарсан эсэх, гарсан бол ямар ажил хийгдсэн талаар тайлагнаагүй байгааг харгалзан 70 хувийн хэрэгжилттэй;
31. 6.1.7-д заасан “Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, энэ хүрээнд Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилт 30 хувьд хүрсэн байх” арга хэмжээний биелэлтийг Засгийн газраас 100 хувь гэж үнэлснийг Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлагдаагүй, уг арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй байгааг харгалзан 90 хувийн хэрэгжилттэй;
32. 6.2.11-д заасан “Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг “Сумын хөгжил” арга хэмжээнд хамруулах арга хэмжээний биелэлтийг Засгийн газар 100 хувиар үнэлснийг зарим сумдын орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулах, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, шинэлэхтэй холбоотой ямар ажил хийгдсэнийг тайлагнаагүй, төлөвлөсөн ажил дутуу гүйцэтгэлтэй байгааг харгалзан 70 хувийн хэрэгжилттэй гэж тус тус үнэллээ.

## **1.2.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ЗААСАН ЗОРИЛТЫН ХЭДЭН ХУВЬД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан нийт 965 арга хэмжээний 25.2 хувь буюу 243 арга хэмжээ нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байна. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 243 арга хэмжээнээс 75 арга хэмжээ буюу 32.4 хувь (давхардаагүй арга хэмжээний тоо) нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагджээ.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг тооцоход Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн арга хэмжээ бүрээр шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг жил бүрээр тодорхой тусгаагүйгээс хүндрэлтэй байна.

**Хүснэгт 5. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа**

Бүлгийн дугаар	Бүлэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо		
			Алсын хараа-2050	МУХТЖУЧ	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	64	16	1
2	Хүний хөгжил	7	161	49	10
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	89	27	4
4	Эдийн засаг	6	165	35	10
5	Засаглал	6	99	25	7
6	Ногоон хөгжил	4	64	18	16
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	116	23	7
8	Бүс, орон нутгийн хөгжил	3	57	29	14
9	Улаанбаатар ба дагуул хот	5	150	21	6
<b>НИЙТ ДҮН</b>		<b>47</b>	<b>965</b>	<b>243</b>	<b>75</b>

Эх сурвалж: “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн явцын тайланд тусгагдсан 9 бүлгийн 47 зорилт, 243 арга хэмжээ, 150 хөрөнгө оруулалтын арга хэмжээ, 87 шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийлээ.

**Хүснэгт 6. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүлэг, зорилт, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, шалгуур үзүүлэлтийн тоо**

Бүлгийн дугаар	Бүлгийн нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хөрөнгө оруулалтын тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	16	6	3
2	Хүний хөгжил	7	49	19	29
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	27	14	11
4	Эдийн засаг	6	35	56	14
5	Засаглал	6	25	9	6
6	Ногоон хөгжил	4	18	6	13
7	Амар тайван аюулгүй нийгэм	5	23	11	2
8	Бүс, орон нутгийн хөгжил	3	29	18	6
9	Улаанбаатар ба дагуул хот	5	21	11	3
<b>Дүн</b>		<b>47</b>	<b>243</b>	<b>150</b>	<b>87</b>

Эх сурвалж: Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтийн тайлан

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу үнэлгээ хийхэд 73.4 хувьтай гарч, “тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэй гарсан.

**Хүснэгт 7. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн үнэлгээ**

Бүлгийн н	Зорилт	Арга хэмжээ	Дундаж үнэлгээ	
			Засгийн газар	УИХ-ын Тамгын газар
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	69.1	68.3
2	Хүний хөгжил	49	68.2	66.6



3	Амьдралын чанар ба дундаж давхарга	27	77.9	74.2
4	Эдийн засаг	35	71.5	71.5
5	Засаглал	25	58.6	58.6
6	Ногоон хөгжил	18	74.3	73.9
7	Амар тайван, аюулгүй нийгэм	23	83.9	83.9
8	Бүс, орон нутгийн хөгжил	29	83.5	83.3
9	Улаанбаатар ба дагуул хот	21	80.6	80.6
	<b>Нийт</b>	<b>243</b>	<b>74.2</b>	<b>73.4</b>

Хүснэгтэд харуулснаар 9 бүлэг, 47 зорилтын 243 арга хэмжээнээс 53 арга хэмжээ нь “үр дүнтэй”, 133 арга хэмжээ нь “тодорхой үр дүнд хүрсэн”, 57 арга хэмжээ нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй гарсан.

**Хүснэгт 8. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2022 оны хэрэгжилтийн явцын хэрэгжилтийн үнэлгээ, бүлэг бүрээр**

д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	1	2	8	4	1	0	68.3
2	Хүний хөгжил	49	7	3	27	8	4		66.6
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	27	6	5	11	5	-	-	74.2
4	Эдийн засаг	35	6	4	12	6	7	-	71.5
5	Засаглал	25	3	2	9	6	-	5	58.6
6	Ногоон хөгжил	18	2	4	8	4	0	0	73.9
7	Амар тайван, аюулгүй нийгэм	23	9	6	7	0	1	0	83.9
8	Бүс, орон нутгийн хөгжил	29	10	9	7	3	0	0	83.3
9	Улаанбаатар ба дагуул хот	21	9	0	9	3	0	0	80.6
	<b>Нийт</b>	<b>243</b>	<b>53</b>	<b>35</b>	<b>98</b>	<b>39</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>73.4</b>

Хэрэгжилтийн талаар тайлагнаагүй улмаас үнэлэх боломжгүй 5 арга хэмжээ байна. Эдгээр арга хэмжээнүүдийг үнэлэх боломжгүй учраас “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцын хэрэгжилтийн үнэлгээ буурсан.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн МУХТЖҮЧ-ийн хэрэгжилтийн явцын тайланд тусгагдсан 11 зорилт, арга хэмжээнд дараах үндэслэлээр үнэлгээг бууруулсан болно. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцыг үнэлж, 50 хувиас бага биелэлттэй нийт 57 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх нь зүйтэй байна.

**“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдал:**

Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хөтөлбөрийн хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 2021-2025 онд нийт 49.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 150 төсөл, арга хэмжээ тусгагдсан байна. Эдгээр 150 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2021-2022 онд нийт 24.5 их наяд төгрөг төлөвлөснөөс 9.5 их наяд төгрөгийг зарцуулж, 38.7 хувийн биелэлттэй байна.

**Хүснэгт 9. “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдал, бүлэг бүрээр /сая.төгрөг/**

Бүлгийн нэр	Арга хэмжээ	2021-2022 оны санхүүжилтийн нийт дүн			2021-2025 оны нийт төсөвт өртөг		
		Төлөв	Гүйц	Биелэлт	Төлөвлөгөө	Гүйц	Биелэлт
Үндэсний нэгдмэл үнэт зүйл	6	326,535.4	88,627.3	27.1%	459,088.6	170,340.5	37.1%
Хүний хөгжил	19	1,209,502.4	760,990.7	62.9%	2,633,902.6	1,271,275.2	48.3%
Амьдралын чанар дундаж давхарга ба	14	828,466.9	395,020.9	47.7%	2,901,944.6	855,754.3	29.5%
Эдийн засаг	56	18,929,773.9	7,248,535.8	38.3%	34,675,916.5	10,924,574.1	31.5%
Засаглал	9	225,800.4	150,229.9	66.5%	553,409.5	382,289.9	69.1%
Ногоон хөгжил	6	842,499.5	81,118.1	9.6%	1,136,794.1	115,195.0	10.1%
Амар тайван аюулгүй нийгэм	11	398,225.0	123,159.8	30.9%	744,494.5	171,742.4	23.1%
Бүс, орон нутгийн хөгжил	18	944,765.7	401,123.4	42.5%	4,977,899.1	797,358.0	16.0%
Улаанбаатар ба дагуул хот	11	813,236.2	244,702.6	30.1%	1,607,220.5	482,216.9	30.0%
<b>Нийт дүн</b>	<b>150</b>	<b>24,518,805.4</b>	<b>9,493,508.5</b>	<b>38.7%</b>	<b>49,690,670.0</b>	<b>15,170,746.3</b>	<b>30.5%</b>

**Шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн байдал:**

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хавсралтаар баталсан 95 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийлээ. Эдгээр шалгуур үзүүлэлт бүрийн 2022 оны хэрэгжилтийг суурь үзүүлэлттэй харьцуулан авч үзэхэд 2022 онд 59 үзүүлэлт өссөн, 36 үзүүлэлт суурь түвшиндээ хүрээгүй байна. Зарим үзүүлэлтүүдийн суурь оны түвшин тодорхойгүй байгаа учраас үнэлэх боломжгүй байна.

**1.3.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ЗААСАН ЗОРИЛТЫН ХЭДЭН ХУВЬД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАСАН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

**“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:**

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан нийт арга хэмжээг үнэлэхдээ 2022 оны хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хянан үзэж арга хэмжээ тус бүрээр үнэллээ.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 6 бодлогын хүрээнд нийт 259 зорилт, 1031 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс ЗГХЭГ-аас ирүүлсэн тайланд 816 арга хэмжээний хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 131 арга хэмжээг ирүүлээгүй байна.

Түүнчлэн 2022 оны байдлаар хэрэгжих хугацаа болоогүй 23 арга хэмжээ, 2021 онд бүрэн хэрэгжиж дууссан 40 арга хэмжээ, нууцын журмаар тайлагнасан 21 арга хэмжээ буюу нийт 84 арга хэмжээний хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй тул хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд тооцоогүй болно.


ЗГХЭГ-аас 2022 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилтийг 69.8 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж ирүүлсэн бол Улсын Их Хурлын Тамгын газраас хөтөлбөрийн хүрээнд

хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны биелэлтийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэхэд хэрэгжилтийн **дундаж 55.0 хувьтай** буюу “хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэллээ. Үүнд:

**Хүснэгт 10.** “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтийн үнэлгээ

№	Бодлого	Зорилтын тоо	Төлөвлөсөн арга хэмжээний тоо	Хэрэгжилт ирүүлсэн арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн дундаж хувь	
					ЗГХЭГ-ын үнэлгээ	УИХ-ын Тамгын газрын үнэлгээ
1	“КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	15	37	35	83.1%	71.4%
2	Хүний хөгжлийн бодлого	55	254	207	63.9%	55.9%
3	Эдийн засгийн бодлого	80	387	309	64.6%	44.6%
4	Засаглалын бодлого	70	272	185	70.2%	63.9%
5	Ногоон хөгжлийн бодлого	12	34	34	65.6%	46.2%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	27	47	46	71.5%	48.0%
<b>Нийт</b>		<b>259</b>	<b>1031</b>	<b>816</b>	<b>69.8%</b>	<b>55.0%</b>

**Зураг 4.** “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээний харьцуулалт



Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад ЗГХЭГ-аас 2022 оны хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй бөгөөд зорилтын хэрэгжилтийн хувийг өссөн дүнгээр ирүүлсэн тул 2022 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг Улсын Их Хурлын Тамгын газраас үнэлсэн болно.

**“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний уялдааны талаар:**

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 6 бодлогын хүрээнд нийт 259 зорилт, 1031 арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан 6 бодлогын 300 арга хэмжээтэй уялдаж байгаа эсэхэд шинжилгээ хийлээ.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 300 арга хэмжээнээс 276 арга хэмжээ нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны

хөтөлбөр”-т тусгасан 328 арга хэмжээтэй уялдаж байгаа бөгөөд бодлогын баримт бичгүүдийн уялдаа 92.0 хувьтай байна.

Харин Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт арга хэмжээнээс 24 арга хэмжээ буюу 8.0 хувь нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан арга хэмжээтэй уялдаагүй байна.

**Хүснэгт 11.** Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн уялдаа

№	Бодлого	УХЖТ-нд тусгасан нийт арга хэмжээ	Агуулгын хувьд уялдаж буй арга хэмээний тоо		Бодлогын баримт бичгүүдийн уялдаа /хувиар/
			УХЖТ-нд тусгасан арга хэмжээ	ЗГҮАХ-т тусгасан арга хэмжээ /давхардсан тоогоор/	
1	“КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	8	8	8	100%
2	Хүний хөгжлийн бодлого	80	79	79	99%
3	Эдийн засгийн бодлого	115	107	156	93%
4	Засаглалын бодлого	53	53	53	100%
5	Ногоон хөгжлийн бодлого	20	20	22	100%
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	24	9	10	37.5%
<b>Нийт</b>		<b>300</b>	<b>276</b>	<b>328</b>	<b>92.0%</b>

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 6 бодлогоос “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого”-ын хүрээнд баталсан нийт 24 арга хэмжээнээс 9 арга хэмжээ буюу 37.5 хувь нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т уялдаатай байгаа нь хамгийн бага хувийн уялдааг хангасан төлөвлөлт болжээ.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 300 арга хэмжээнээс “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 328 арга хэмжээтэй уялдаж буй 276 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл:

- “үр дүнтэй” буюу 100 хувийн 65 арга хэмжээ;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 106 арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 31-69 хувийн хэрэгжилттэй 39 арга хэмжээ;
- “үр дүнгүй” буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 62 арга хэмжээ;
- “үнэлэх боломжгүй” буюу нууцын журмаар тайлагнасан 4 арга хэмжээ тус тус байна.

**Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь “Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин батлагдсан.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд шинжилгээ хийлээ.

Нийт 6 бодлогын хүрээнд 152<sup>2</sup> шалгуур үзүүлэлтийг баталсан бөгөөд 2022 оны шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хэрэгжилтийн хувь тус бүрээр авч үзвэл:

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 68 үзүүлэлт;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 36 үзүүлэлт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 31-69 хувийн хэрэгжилттэй 13 үзүүлэлт;
- “үр дүнгүй” буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 17 шалгуур үзүүлэлт;
- “үр дүн тодорхойгүй” буюу хүрсэн түвшинг тайлагнаагүй 18 үзүүлэлт байна.

2022 оны байдлаар нийт 152 шалгуур үзүүлэлтээс үр дүнгүй буюу зорилтот түвшинд хүрээгүй 17 шалгуур үзүүлэлт, үр дүн тодорхойгүй буюу хүрсэн түвшинг тайлагнаагүй 18 шалгуур үзүүлэлт байна.<sup>3</sup> Үүнээс “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд баталсан нийт 44 шалгуур үзүүлэлтээс 10 үзүүлэлтийг тайлагнаагүй буюу шинжлэх ухаан болон хүн амын хөгжлийн үзүүлэлтүүд тодорхойгүй байна. Түүнчлэн засаглалын бодлогын хүрээнд баталсан 31 шалгуур үзүүлэлтээс 7 шалгуур үзүүлэлтийг тайлагнаагүй буюу авлигын хяналт, засгийн газрын үр нөлөө, хуулийн засаглал, иргэдийн дуу хоолой ба харицлага /дэлхийн банкны засаглалын үзүүлэлтээр хэмждэг/ зэрэг үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин тодорхойгүй байна.

**Хүснэгт 12.** Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

Д/д	БОДЛОГО	Нийт баталсан шалгуур үзүүлэлт	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Хүрсэн түвшинг тайлагнаагүй
			/100 хувь/	/70-99 хувь/	/31-69 хувь/	/0-30 хувь/	
1	“КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	-	1	-	-	-
2	Хүний хөгжлийн бодлого	44	16	7	4	7	10
3	Эдийн засгийн бодлого	49	23	16	4	6	-
4	Засаглалын бодлого	31	17	3	2	2	7
5	Ногоон хөгжлийн бодлого	14	3	8	2	-	1
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	13	9	1	1	2	-
<b>Нийт</b>		<b>152</b>	<b>68</b>	<b>36</b>	<b>13</b>	<b>17</b>	<b>18</b>

**ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗААСАН АРГА ХЭМЖЭЭ НЬ БҮРЭН ХЭРЭГЖСЭН ЭСЭХЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд заасан 300 арга хэмжээнээс 232 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй буюу 100-аас бага хувийн хэрэгжилттэй, үлдсэн 68 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй байна.

Бүрэн хэрэгжээгүй арга хэмжээнүүдэд шинжилгээ хийж үзэхэд 43.6 хувь нь үйл ажиллагааны зохион байгуулалтаас, 38 хувь нь төлөвлөлтөөс, 12.2 хувь нь санхүүжилтийн

<sup>2</sup> Хавсралт 3-аас Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг үзнэ үү.

<sup>3</sup> Хавсралт 4-өөс Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан шагуур үзүүлэлт хангаагүй болон үр дүн тодорхойгүй үзүүлэлт

асуудлаас, 5.4 хувь нь шийдвэр гаргалтын удаашралаас, 0.8 хувь нь дотоодоос хамааралгүй хүчин зүйлсээс шалтгаалж, хэрэгжилт нь бүрэн хангагддаггүй гэсэн үр дүн гарсан.

**Зураг 5.** Бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийн бүтэц



Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд заасан бүрэн хэрэгжээгүй арга хэмжээний хувьд цаашид үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, судалгаа, тооцоолол, бэлтгэл ажлыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, оновчтой, нягт нямбай төлөвлөх, санхүүжилтийн асуудлыг төсөвт тусгах болон өөр эх үүсвэрээс дайчлах замаар шийдвэрлэх, хэрэгжилтийг нь хангуулах, холбогдох шийдвэрийг алгуурлахгүйгээр гаргаж хэвших, хэрэгжилтэд нь хяналт тавих, системийн хувьд болзошгүй эрсдэлийг тооцож, удирдлага, зохион байгуулалтаар хангах шаардлагатай байсан байна.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэл, үр дүнгийн дундаж үнэлгээ **65.2 хувьтай** байгаагаас “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 85.6 хувь, Хүний хөгжлийн бодлого 65.4 хувь, Эдийн засгийн бодлого 60.6 хувь, Засаглалын бодлого 67.5 хувь, Ногоон хөгжлийн бодлого 57.1 хувь, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого 81.3 хувь байна.
2. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 300 арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээр үр дүнтэй хэрэгжсэн 68 арга хэмжээ буюу 22.7 хувь, тодорхой үр дүнд хүрсэн 119 арга хэмжээ буюу 39.7 хувь, эрчимжүүлэх шаардлагатай 87 арга хэмжээ буюу 29.0 хувь, үр дүнгүй буюу зорилтот үр дүнг хангаагүй 26 арга хэмжээ буюу 8.7 хувь байна.
3. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 300 арга хэмжээнээс Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөгжлийн зорилт, хүрэх үр дүнтэй 75 (давхцаагүй) арга хэмжээг уялдуулсан бол Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнтэй 328 арга хэмжээ буюу 92.0%-ийг нь уялдуулан тусгасан байна.
4. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоолол судалгаа хийгдээгүй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг боловсруулаагүй зэрэг хуулийн шаардлага хангаагүй арга хэмжээг тусгасан нь бодлогын зорилт, хүрэх үр дүн биелэх нөхцөлийг бууруулж байна.
5. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулахдаа зарим арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгийн хэмжээг урьдчилан тооцоолоогүй байна.
6. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хэмжих хяналт шинжилгээ, үнэлгээний 152 шалгуур үзүүлэлт, хүрэх

түвшинг урьдчилан баталсан. Монгол Улсын Засгийн газраас 2022 оны шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшинг тоон болон хувиар илэрхийлж тайлагнасан боловч 2022 онд хүрсэн түвшинг бодитой эсэхийг хянан үзэхэд шаардлагатай мэдээллийг тайланд тодорхой дурдаагүй байна.

7. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тайлагнахдаа суурь түвшин буюу тухайн бодлогын баримт бичиг батлагдах үеийн хэрэгжилтийг тайлагнах, мөн 2022 оны өссөн дүнгээр үнэлж ирүүлсэн боловч 2020, 2021 оны хэрэгжилтээс хойш гарсан ахиц өөрчлөлтийг тайлагнаагүй буюу тайлангийн чанар хангалтгүй байна.
8. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон бусад бодлогын баримт бичгийн уялдаа, тухайн жилийнхээ зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу бодитоор үнэлж, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн хувьд эрсдэлийн үнэлгээ хийдэг байх шаардлагатай байна.

### Зөвлөмж

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан арга хэмжээг түлхүү тусгаж, хөгжлийн үзүүлэлтүүдийн шалгуурыг илүү сайн түвшинд хангах боломж байсан эсэхэд дүгнэлт хийх;
2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний бодлогын зорилтуудад дунд хугацааны хөгжлийн бичиг баримтуудаас ямар төрлийн, хэдэн арга хэмжээг, ямар үндэслэлээр тусгасан талаар хяналт, шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулан тайлагнадаг байх;
3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан арга хэмжээнүүдийг жил, жилээр нь зорилт, арга хэмжээ болон хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, цаг хугацаа, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, шийдвэр гаргалт, санхүүжилт, түүний эх үүсвэр, төслийн гүйцэтгэгч байгууллага, үл хөдлөх болон эргэлтийн хөрөнгө, төслөөс гарсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгч зэрэг төслийн үзүүлэлтүүдээр хэмжих, нэгтгэх, салган дүгнэх боломжийг олгохуйц түвшинд цогцоор нь төлөвлөдөг болох;  
Энэ нь урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн үндэслэл, харилцан уялдааг сайжруулах, бодлогын тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой байна;
4. Бодлогын баримт бичгийн биелэлтийн тайланг ирүүлэхдээ эх үүсвэргүй арга хэмжээг төслийн хэрэгжилтийн явцад санхүүжүүлсэн бол холбогдох шийдвэр, хууль зүйн үндэслэлийг хамтад нь тайлбарлаж ирүүлдэг байх;
5. Арга хэмжээний хүрэх үр дүнг төлөвлөхдөө аль болох хэмжигдэхүйц утгаар илэрхийлэх, тухайн хувь хэмжээнд хамаарах ажлын гүйцэтгэл, гол үр дүнг хамтад нь төлөвлөх, тайлагнах;
6. Төсөл, арга хэмжээний зураг төсөв, газрын асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэдэг байх, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой судалгаа явуулах, тендер зохион байгуулах, гэрээ хийх зэрэг бэлтгэл ажлуудыг шуурхай зохион байгуулж хэвших;
7. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа хөрөнгө оруулалт, арга хэмжээ бүрийг төгрөгөөр илэрхийлж, биелэлтийг тайлагнадаг байх, хэрэв бусад орны мөнгөн тэмдэгтээр илэрхийлж тайлагнах тохиолдолд гадаад валютын ханшийн талаарх мэдээллийг тусгадаг байх;

8. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийн тайлан болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн биелэлтийн тайлан ирүүлээгүй, хөгжлийн бодлогын баримт бичгийн үнэлгээг бууруулсан төрийн байгууллагуудад хариуцлага тооцдог байх;
9. Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнд зориулан төсөв, санхүүжилтийг төлөвлөгөөний дагуу бүрэн тусгадаг байх;
10. Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээ бүрээр ажлын процессийн дараалал гаргах, ажлын процессийн дагуу биелэлтийг тухайн оны болон өссөн дүн байдлаар ялгаж ирүүлэх, үүнтэй уялдуулан үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд өөрчлөлт оруулах;
11. Бодлогын баримт бичгүүдийн зорилтуудыг тэргүүлэх болон дэмжих зорилт, чиглэл байдлаар бүрэн зураглалыг ажлын процессийн дараалалтай уялдуулан гаргаж, бүлгийн зорилт, арга хэмжээ бүрийн уялдаа холбоог тодорхойлж, тайлагнадаг байх.

---oOo---